



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар A/491

Ховд

Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а” дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Зэрэг суманд хэрэгжсэн Сургуулийн барилгын их засвар /Ховд, Зэрэг сум/, Ховд аймгийн Зэрэг сумын хүүхэд, залуучуудын спортын талбайн тохижилтын ажлуудад иргэнээс гаргасан гомдлын дагуу хийсэн ажлын чанар стандартыг дахин нягтлан шалгаж дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Г.Цэдэнбал - Монгол Улсын гавьяат барилгачин

А.Жамъяансүрэн - Мэргэжлийн хяналтын газрын хэлтсийн дарга, Улсын ахлах байцаагч

Д.Октябрь - Зэрэг сумын Засаг дарга


Нарийн бичгийн

дарга Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Дээрх ажлуудыг зураг, төсөв, стандартын дагуу хуулийн хүрээнд гүйцэтгэсэн эсэхэд нягтлан шалгаж дүгнэлт гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/- д даалгасугай.

3. Дээрх ажлуудад шалгалт хийхтэй холбогдон гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style.

Б.ДҮГЭРЖАВ